



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/301

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт  
үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ийн  
эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9,317,700 /Есөн сая гурван зуун арван долоон мянга долоон зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ /С.Мөнхбат/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 4,413,800 /Дөрвөн сая дөрвөн зуун арван гурван мянга найман зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах 7 нэр төрлийн 4,903,900 /Дөрвөн сая есөн зуун гурван мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж хасахыг Сонгинохайрхан дүүргийн “Тээвэрлэлт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ /С.Мөнхбат/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ


Ш.ҮНЭНБАТ



D:\Tushaal 2019\Tushaal-1\8 cap.docx

115050000937

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 08...сарын  
 15... өдрийн А/Б/О/ дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн "Тээвэрлэлт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2019.07.31/	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Модон сандал	5	ш	5	90,000	450,000	266,250	183,750	эвдэрсэн	татах
2	Сандал дугуйтай	8	ш	2	57,950	115,900	114,934	966	эвдэрсэн	устгах
3	Дугуйтай сандал /никель/	5	ш	2	250,000	500,000	295,833	204,167	эвдэрсэн	устгах
4	Баримт үдэгч	8	ш	1	67,000	67,000	67,000	-	эвдэрсэн	татах
5	5 ханатай гэр	6	ш	1	2,800,000	2,800,000	1,633,333	1,166,667	эвдэрсэн	татах
6	Гэрийн бүрээс	4	ш	1	387,000	387,000	154,800	232,200	угжирсан	татах
<b>Тавилга эд хогшлын дүн</b>				12		4,319,900	2,532,151	1,787,749		
7	Ус цэвэршүүлэгч /жижиг/	4	ш	1	350,000	350,000	131,250	218,750	эвдэрсэн	татах
8	Зургийн аппарат /soni/	10	ш	1	300,000	300,000	300,000	-	эвдэрсэн	татах
9	Зургийн аппарат /nikon/	4	ш	1	549,900	549,900	549,900	-	эвдэрсэн	татах
10	HP notebook	9	ш	1	1,399,000	1,399,000	1,399,000	-	хулгайд алдагдсан	устгах
11	SAMSUNG Notebook	9	ш	1	1,199,900	1,199,900	1,199,900	-	хулгайд алдагдсан	устгах
12	ACER notebook	9	ш	1	1,199,000	1,199,000	1,199,000	-	хулгайд алдагдсан	устгах
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>				6		4,997,800	4,779,050	218,750		

<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>	18		9,317,700	7,311,201	2,006,499		
Үүнээс: Худалдах хөрөнгө							
Актлах хөрөнгө			4,413,800	4,208,668	205,133		
Татан төвлөрүүлэх хөрөнгө			4,903,900	3,102,533	1,801,367		
Худалдсанаас олох орлого							
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/							